



**Авлигатай тэмцэх газар**

**Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс**

# **АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ**

**2022 он**



## ШИНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ



СОЁЛЫН ӨВИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ



МӨНГӨ УГААХ  
ГЭМТ ХЭРЭГ




АВЛИГА АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ  
ХЭРЭГ



КИБЕР ГЭМТ ХЭРЭГ



ХҮҮХДИЙН ЭСРЭГ  
ГЭМТ ХЭРЭГ





ХАР ТАМХИ, ХҮН ХУДАЛДААЛАХ  
ГЭМТ ХЭРЭГ



# Corruption Perception Index 2021

Берлинд төвтэй  
Транспаренси  
Интернешнл олон  
улсын төрийн бус  
байгууллагаас  
дэлхийн 180 орны  
төрийн албан дахь  
авлигын талаар  
шинжээч, бизнес  
эрхлэгчдийн  
төсөөлөлд үндэслэн  
Авлигын төсөөллийн  
индексийг гаргадаг.




Индексийн дүнгээр Монгол Улс 2021 онд 35 оноо авч 110-д байна.





**1.АВЛИГА ГЭЖ ЮУ ВЭ?**



**2.АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ ГЭЖ ЮУ ВЭ?**

**ТАНЫ БОДЛООР ...?**





2015 онд батлагдаж 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 11 төрлийн гэмт хэргийг Авлигатай тэмцэх газар шалгадаг.

**2015 оны Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан 11 төрлийн гэмт хэрэг:**

- 22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах
- 22.3 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах
- 22.4 дүгээр зүйл. Хахууль авах
- 22.5 дугаар зүйл. Хахууль өгөх
- 22.6 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах
- 22.7 дугаар зүйл. Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх
- 22.8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
- 22.9 дүгээр зүйл. Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
- 22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих
- 22.11 дүгээр зүйл. Дураараа аашлах
- 22.12 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах

Авлигатай тэмцэх газрын үндсэн бүтцэд хэрэг бүртгэх, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий Мөрдөн шалгах хэлтэс байдаг бөгөөд тус хэлтэс нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар харьяалуулсан, **Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан 11 төрлийн гэмт хэрэгт;**

**АТГ** илрүүлсэн **“Мөнгө угаах”** төрлийн гэмт хэрэгт;

Улсын Ерөнхий прокурорын 2020 оны А/33 тушаалаар шинэчлэн батлагдсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах харьяаллын дагуу **“Цагдаагийн албан хаагч нарт холбогдох гэмт хэргийн шинжтэй гомдол, хэрэг бүртгэлтийн болон мөрдөн байцаалтын хэрэг”-т** мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна.



# ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ЗААСАН ЯЛЫН ТӨРӨЛ



ТОРГОХ



НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ



ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ



ХОРИХ




ЭРХ ХАСАХ- нэмэгдэл ялаар хэрэглэнэ.

Үндсэн ялаар хэрэглэнэ.





# Иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн гомдлын Тоон мэдээлэл



— Авлигын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл

— Ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл





## “ХУУЛИЙН ТАЙЛБАР”

**“Улс төрд нөлөө бүхий этгээд”** гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргыг ойлгоно. /[НБНБХАСЗХАСЗТХууль.20 зүйл](#)/

**“Нийтийн албан тушаалтан”** гэж Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд хуульчлагдснаар ойлгоно.


**“Албан үүрэг, бүрэн эрх”** гэж Улсын дээд шүүхийн 2009 оны 23 дугаар тогтоолоор баталсан тайлбарт заасны дагуу *“Сонгууль болон томилолтын албан тушаалтанд хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, үндсэн чиг үүргийн нэгдэл”* гэж ойлгоно.

**“Албан тушаалын байдал”** гэж мөн тайлбарт заасны дагуу *“Албан тушаалтны хэрэгжүүлж байгаа эрх, үүрэгт хамааралгүй боловч тухайн албан тушаалтай холбоотой нэр хүнд, нөлөө”*-г хэлнэ.





## 22.1.1-3 дугаар зүйл. “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах”





## Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн жишээ:


1. .... аймгийн ..... Төрийн байгууллагын дарга Д нь албаны бүрэн эрхээ урвуулан ашиглаж, өөрийн хамаарал бүхий этгээд Т-г жижүүр, мужааны ажилд томилсон тушаал гаргаж, улмаар 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 2022 оны 07 дугаар сарын 30-ны өдөр хүртэл цалин бодуулан, хувьдаа завшсан.

2. .... Их сургуулийн захирал А нь өөрийн албан тушаалын байдлаа ашиглан, сургуулийн багш нарт нөлөөлөх байдлаар өөрийн төрсөн хүүхдийн дүнг засварлаж, өөрчлөлт оруулж, сургуулиас тэтгэлэг 3 удаа олгосон, тус сургуулийн нэрийн өмнөөс гадаадын их, дээд сургуульд оюутан солилцоогоор холбогдох журам, хууль тогтоомжийг зөрчиж сургасан.



## 22.4 дүгээр зүйл “Хахууль авах”

**Эрүүгийн хариуцлага:**






## Хахууль авах гэмт хэргийн жишээ:

1. Иргэн Ж нь 2021 онд хүнсний худалдаа, үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл авахын тулд тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий төрийн байгууллагын удирдах албан тушаалтан О-г өөрийн эзэмшлийн ресторанд хүлээн авч, дайлсан. Түүнчлэн өөрийн өмчлөлд байсан Ү-5281 хxxx улсын бүртгэлийн дугаартай зуслангийн зориулалттай газрыг бэлэглэлийн гэрээгээр О-д шилжүүлсэн.
2. Төрийн өмчит ХХК-ийн захирал Б нь тус ХХК-ийн ахлах нягтлан бодогчийн сул орон тоонд ажлын байрны шаардлага, шалгуур хангахгүй, сонгон шалгаруулалтад ороогүй иргэн Х-г шууд томилсоны хариуд 4,0 сая төгрөг бэлнээр авсан. Энэ үйлдэлд тус компанийн менежер У зуучилж оролцсон.



## 22.5 дугаар зүйл “Хахууль өгөх”



### Эрүүгийн хариуцлага:

- Нийтийн албанд томилогдох эрхийг **хоёр /2/ жил** хүртэл хугацаагаар хасаж дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний /450.000-14.000.000/ төгрөгөөр **торгох**,
- Эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаа /1 сар-3 жил/-аар **зорчих эрхийг хязгаарлах**,
- Эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаа /1 сар-3 жил/-аар **хорих ял** шийтгэнэ.
- Нийтийн албанд томилогдох эрхийг эрхийг хоёр жилээс таван жил /2-5/ хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгж /5.400.000-27.000.000/-тэй тэнцэх хэмжээний төгрөгөөр **торгох**,
- Эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаа /1-5/-аар **зорчих эрхийг хязгаарлах**,
- Эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаа /1-5/-аар **хорих ял** шийтгэнэ.



## **Хахууль өгөх гэмт хэрэгт эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл:**

**Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж, эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.**



## ХЯСАН БООГДУУЛСАН БОЛОН ХЯСАН БООГДУУЛСАН ГЭЖ ҮЗЭХГҮЙ 2 НӨХЦӨЛ БАЙДЛЫН ЯЛГАА

### ХЯСАН БООГУУДЛСАН ГЭЖ ҮЗЭХ ТОХИОЛДОЛ:

Хүнсний худалдаа, борлуулалтын тусгай зөвшөөрөлтэй “Б” ХХК нь БНХАУ-аас Замын-Үүдийн боомтоор түргэн муудах хүнсний бараа бүтээгдэхүүнийг Монгол Улс руу оруулж ирэх явцад, хилийн Мэргэжлийн хяналтын Улсын байцаагч 3 нь албан үүрэг гүйцэтгэх явцдаа тус компанийн эрх бүхий албан тушаалтнаас их хэмжээний хахууль нэхэж, албаны чиг үүргээ хэрэгжүүлээгүйн

### Шүүхээс тус үйлдлийг хясан боогдуулсан гэж үзсэн үндэслэл:

“Б” ХХК-ийн оруулж ирж буй хүнсний бүтээгдэхүүн нь түргэн муудах, онцлог чанартай бараа, бүтээгдэхүүн байсан учраас тус компани нь их хэмжээний хохирол хүлээхгүйн тулд төрийн албан хаагчийн тавьсан хууль бус саналыг хүлээн авахаас өөр сонголт байгаагүй бөгөөд нэхсэн хахуулийг татгалзах боломжгүйгээр өгсөн, хилийн Мэргэжлийн хяналтын Улсын байцаагч 3 нь нөхцөл байдлыг өөрт ашигтай байдлаар эргүүлэх, цаг хугацааны богино, давчуу байдлыг ашиглан, өөртөө давуу байдал бий болгож, Б ХХК-ийн албан тушаалтныг гарцаагүй байдалд оруулж, хахууль нэхэж авсан гэж дүгнэлт хийсэн.

### ХЯСАН БООГДУУЛААГҮЙ ГЭЖ ҮЗЭХ ТОХИОЛДОЛ:

Иргэн Б нь Х банкнаас орон сууцны ипотекийн зээл авах ажлаар банкны харилцааны менежер /зээлийн эдийн засагч/-тай уулзаж, хүсэлт гаргасан боловч, харилцааны менежер гаргасан зээлийн 10 хувийг шан, харамж болгон авах, үүний хариуд зээлийг хурдан хугацаанд хахууль өгөгчид ашигтай байдлаар шийдвэрлүүлэх талаар урьдчилан амалж, хахууль авсан.

### Шүүхээс тус үйлдлийг хясан боогдуулсан гэж үзээгүй үндэслэл:

Зээл авсан этгээд нь банкны ажилтны хууль бус үйлдлийн талаар удирдах албан тушаалтан болон төв байгууллага, эсхүл хууль хяналтын байгууллага гэх мэт шат дарааллан гомдол гаргах асуудлыг хууль, журмын дагуу шийдвэрлүүлэх, бусдад хахууль өгөхөөс зайлсхийх боломж байсан гэж шүүхээс дүгнэсэн.



## ТӨСӨВ ГЭЖ:

Төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг ойлгоно.

## ТӨРИЙН ӨМЧ ГЭЖ:


***Төр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж болох дараахь эд хөрөнгө хамаарна:***

1. Төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө;
2. Төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө;
3. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрд ногдох хувь хөрөнгө;
4. Улсын төсвийн хөрөнгө болон төрийн бусад тусгай сан;
5. Төрийн тусгай хэрэгцээний бэлтгэл нөөц;
6. Хуульд заасан бусад төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн байгууллагын хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө;





## 22.8 дугаар зүйл “Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах”



### Хүлээлгэх эрүүгийн хариуцлага:

- Нийтийн албанд томилогдох **эрхийг** гурван жил **/3/** хүртэл хугацаагаар **хасаж** таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгж **/5.400.000-27.000.000/-**тэй тэнцэх хэмжээний **төгрөгөөр торгох,**
- Эсхүл нэг жилээс таван жил **/1-5/** хүртэл хугацаагаар **зорчих эрхийг хязгаарлах,**
- Эсхүл нэг жилээс таван жил **/1-5/** хүртэл хугацаагаар **хорих ял шийтгэнэ.**



## 22.10 дугаар зүйл “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих”

1.Нийтийн албан тушаалтан



Өөрийн хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй бол



Эрүүгийн хариуцлага

Үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж, нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох

Эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах,  
Эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эсхүл нэг жилээс таван жил /1-5/ хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах,  
Эсхүл нэг жилээс таван жил /1-5/ хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ



## Жишээ:

Төрийн байгууллагын удирдах албан тушаалтан А нь өөрийн 2 хүүхдийг жилийн 30 сая төгрөгийн төлбөртэй хувийн дунд сургуульд сургадаг, хувьдаа 2 автомашинтай, зах зээлийн үнэлгээгээр 500,000,000 сая төгрөгийн үнэ бүхий хувийн орон сууцанд амьдардаг талаар иргэнээс АТГ-т мэдээлэл ирүүлсэн.

Нөхцөл байдлыг судлан үзэж, тухайн асуудалд АТГ-аас мөрдөн шалгах ажиллагааг явуулахад тухайн төрийн албан тушаалтан нь хувьдаа ямар нэг бизнесгүй, гэр бүлийн гишүүд болон хамаарал бүхий этгээдүүд нь бизнес эрхэлдэггүй, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад гүйцэтгэх ажил эрхэлдэг, их хэмжээний орлого олох ямар нэг эх үүсвэр байхгүй болох нь тогтоогдсон.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад тухайн этгээд өөрийн олсон хөрөнгө, орлогоо үндэслэлтэй тайлбарлаж чадаагүйгээс гадна, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ худал гаргасан болох нь баримтаар нотлогдсон.


Түүнээс гадна олсон орлого, авсан зарим хөрөнгө нь албаны бүрэн эрх, албан тушаалын нэр хүндийг ашиглан хууль бус шийдвэр гаргах, бусдаар шийдвэр гаргуулах зэргээр өөртөө болон бусдад давуу байдал бий болгож, үүний хариуд шууд болон бусдаар дамжуулан хахууль авах зэрэг хэд хэдэн гэмт хэрг үйлдсэн нь тогтоогдож, шүүхээс түүнд хуульд заасан ял шийтгэлийг оногдуулсан байна.



## Төрийн албан хаагч, нийтийн албан тушаалтнаас гадна хувийн хэвшил, хуулийн этгээдэд хариуцлага тооцох эрх зүйн орчин бүрдсэн.

Авлигын гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болгосон буюу материаллаг хохирол шаардахгүй, өөртөө болон бусдад давуу байдал бий болгосноор гэмт хэрэг гэж тооцохоор өөрчилсөн нь хувийн хэвшлийнхэн авлигын эсрэг хууль, тогтоомжийг зайлшгүй уншиж судлах шаардлагыг бий болгож байгаа юм.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн **22.4** дүгээр зүйлд заасан хахууль авах гэмт, **22.5** дугаар зүйлд заасан хахууль өгөх гэмт хэрэг, **22.12** дугаар зүйлд заасан хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулах зэрэг гэмт хэргүүдийг хамруулан ойлгож болно.





Авлигатай тэмцэх газар 2019-2020 онд **12.1 их наяд** төгрөгийн хохиролтой эрүүгийн хэрэг шалгасан.


Энэ хэмжээний мөнгөөр 200 000 айл орон сууцтай болж, 1515 эмнэлэг, 2021 сургууль, 6062 цэцэрлэг, 10,540 км хатуу хучилттай авто зам барих боломжтой.



**2022** оны эхний хагас жилд шалгагдсан гэмт хэргийн улмаас **2,061,324,104,812.00** төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад **1,235,701,691,027.44** буюу **59.9** хувийг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг **382,746,448,140.00** төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.



# МӨНГӨӨР ХЭМЖИЖ БОЛОХГҮЙ ХОХИРОЛ?



- Шударга байдал, хууль ёс алдагдана
- Хүний эрх, эрх чөлөө зөрчигдөнө
- Ядуурал нэмэгдэнэ
- Төрд итгэх иргэдийн итгэл буурна
- Соёл, ухамсар доройтно
- Ёс суртахууны доройтол даамжирна
- Амин хувиа хичээх үзэл газар авна
- Хөгжил дэвшил удааширна



ᠠᠨᠬᠠᠭᠠᠷᠠᠨ  
ᠰᠣᠨᠰᠣᠨ  
ᠲᠠ  
ᠪᠦᠬᠡᠨᠳᠦ  
ᠪᠠᠶᠠᠷᠯᠠᠯᠠᠭᠠ

## АТГ - Олон Нийтийн Төв

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

[Нийтлэлүүд](#)

[Тухай](#)

[Дурдсан түүхүүд](#)

[Илүү](#)

[Дагаж байгаа](#)

[Зурвас](#)



**АНХААРАН СОНССОН ТА  
БҮХЭНД БАЯРЛАЛАА**